

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМ



ИЛЧЛЭГ ШИВЭЭ

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**



2023 ОН

“ИЛЧЛЭГ-ШИВЭЭ” ОНӨААТҮГ-ЫН БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Шивээговь сум

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай байгууллага нь 1989 онд Дорноговь аймгийн ЭХНҮ-ийн захирлын 25 тоот тушаалаар анх байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Анх байгуулагдсанаас хойш өдгөө 34 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Манайх халаалтын улиралд Шивээговь сумын төсвийн 6 байгууллага, 34 аж ахуй нэгж, орон сууцны 315 айл өрхийг халаалт, хэрэглээний халуун ус мөн 721 айл өрх, зүүн болон урд гэр хорооллын 192 өрхийг цэвэр усаар хангаж, бохирын шугаманд холбогдсон албан байгууллага, орон сууцны оршин суугчдын бохир усыг сумын төвөөс баруун тийш 3 км-ийн зайд татан зайлуулж жилийн 4 улиралд тасралтгүй дулаан үйлдвэрлэн түгээх, цэвэр ус олборлон түгээх, бохир усыг татан зайлуулах үйл ажиллагаа явуулдаг.

“Илчлэг-Шивээ”ОНӨААТҮГ Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын төвд байрлах ба Улаанбаатар хотын 275 км, аймгийн төв Чойр хотоос зүүн урагш 35 км, Улаанбаатар Замын-Үүд чиглэлийн засмал замаас баруун 7 км-т оршдог.

Шивээговь сумын иргэдийг цэвэр аюулгүй усаар хангах, олборлон түгээж байгаа газрын доорх ус нь Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт хамаарагддаг. Усны эх үүсвэрийн өрөмдмөл 1 дүгээр худаг сумын төвөөс баруун тийш 2,5 км-т байрлах бөгөөд 80-100 м гүнтэй, ЭЦВ-8-25-150 маркын насосаар өргөж ф-259-ийн хуванцар хоолойгоор 2,5 км-т сумын төвд байрлах 500м³ –ийн багтаамжтай усан санд нөөцөлж өргөх станцаас CDL-32-60 маркын насосаар хэрэглэгчдэд түгээж байна. Мөн Шивээговь сумыг ахуйн болон хэрэглээний зориулалт бүхий цэвэр усаар хангах өрөмдмөл 2 худгийг алсын удирдлагын системд, ус түгээх 2 байр ухаалга системд шилжүүлсэн.

Дулааны станц нь 2.33 мВт хүчин чадалтай 2 зуух, 2.0 мВт хүчин чадалтай 3 зуух, 5000 квт-ын ялтсан бойлер 2 ширхэг, 2000квт-ын нэг ширхэг, Дулааны 2-р хэлхээнд Q-200м³/цаг, Н-30м, 30квт-ын 2ш насос, ХХУ-ны Q-100м³/ц, Н-30м, 22квт-ын 2ш насостой.

Халаалтын зуухны түлшинд 20 км зайтай орших Шивээ овоогийн нүүрсний уурхайн нүүрсийг хэрэглэж байна. Төвийн орон сууцны айл өрх, албан байгууллагаас гарч буй бохир усыг газрын 2,5-3 метрийн гүнд ф-159-300 мм-ийн голчтой ширмэн хоолойгоор дамжуулан өөрийн урсацаар сумын төвөөс баруун зүгт 3 км-т ил задгай хаяж байна. Энэ нь хүрээлэн буй байгаль орчныг бохирдуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Сумын төвд ашиглагдаж байгаа бохир усны 72 худаг, 11,2 км шугам хоолой байна. Суманд цэвэрлэх байгууламж байхгүй.

Шивээговь сумын байгаль орчны товч танилцуулга

Газрын гадарга: Шивээговь сум нь хээрийн бүсэд байрладаг тул сумын нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг хээр талын бүсийн гадарга зонхилно. Төвийн суурьшлын баруун хэсэг болон зүүн талаар нилээд талархаг юм. Харин сумын төвөөс урагш болох тусам газрын гадарга тун алгуур өндөр болдог.

Уур амьсгал: Сум нь монгол орны уур амьсгалын мужлалаар 2-р мужид хамрагдах бөгөөд хуурайдуу сэрүүн зунтай, хахирдуу өвөлтэй мужид багтана. Галлагааны 2-р мужид хамрагдах бөгөөд галлагааны хугацаа 09 дүгээр сарын 15-нд эхэлж, 5 дугаар сарын 15-нд дуусна. Галлагааны хугацаа дунджаар 242 хоног үргэлжилнэ. Шивээговь сум нь газар хөдлөлтийн 6 баллын бүсэд оршдог.

Шивээговь суманд голдуу хөндийн салхины гол давтагдал илэрдэг. Тухайлбал жилийн дундаж салхи баруунаас, баруун хойноос зонхилох ба нийт салхилах салхины 40-50 хувь хойноос, 10-20 хувь нь баруун хойноос, үлдсэн нь урд ба бусад зүгээс чиглэсэн салхины давтагдалтай.

Ус зүй: Усан хангамжийн хувьд урсгал ус байхгүй боловч голдуу ундрага багатай Өехий, Нэрт, Бэхт, Хөтөл, Нүхэн, Сэвхүүл, Шивээгийн булаг, Өвгөний хонхорын зэрэг бага урсгалтай горхи булаг шанд элбэг байдаг.


Ургамал: Төвийн дэвсгэр нутгийн хэмжээнд ургамлын бүрхэвч маш сийрэг салхи хур тундасны үйлчлэлээр элс нүүж овоорох, элсэн дов үүссэн зэргээр цөлжилт ихсэж байна. Хаврын улиралд байгалийн маш хүчтэй шороон шуурга болдог учир гуу жалга үүсэж газар ихээр эвдэрч байна. Цаашид дэлхийн дулаарлын нөлөөгөөр хүчтэй шороон шуургын тоо, давтамж улам ихсэх хандлагатай байгаа учраас газрын доройтол цөлжилт улам нэмэгдэнэ.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИГЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

д/д	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хугацаа	Зарцуулсан төсөв,төг	Арга хэмжээний гүйцэтгэл
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, ариглах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ				
1	Агаарын шинжилгээг үйл ажиллагаа идэвхитэй явуулж буй сард хийлгэж сөрөг нөлөөллийг бодитоор гаргаж бууруулах	3,11 сар	528,000.0	<p>Говьсүмбэр аймаг дахь Цаг уур орчны шинжилгээний төв агаарын шинжилгээг 2 удаа хийлгэн сөрөг нөлөөллийг бодитоор гарган агаарын бохирлыг бууруулах арга хэмжээг авч нарийн үнс баригчийг бүх зууханд суурилуулан тогтмол цэвэрлэгээг хийж, яндангаар гарах утааны хийд агуулагдах үнс тоосыг багасгаж ажилласан.</p> 
2	Зуухны шаталтын горимд хяналт тавьж, нүүрс агаарын харьцааг жигд болгох, зуухыг даралтанд орохоос сэргийлэх, ажлын байрны нөхцөлд хяналт тавих.	жилдээ	2,500,000.00	<p>Зуухны шаталтыг горимд хяналт тавьж, нүүрс агаарын харьцааг жигд болгох зорилгоор халаалтын зууханд 5.5квт-2ш, 30квт-1ш, 22-квт-3ш, 7.5квт-2, 11квт-1ш, 18,5 квт-1 нийт 10 ширхэг инвертерүүдийг винтелятор, дымсост тавьж, 10м³ -ын усан сан хэвийн ажиллаж зуухыг даралтад орохоос сэргийлж дулаан хангамжийн усны чанар, зуухны даралтыг хянан ажиллаж байна.</p> <p>Зуухны машинч нарын ажиллах орчны сайжруулан 4 зуухны галлагааны аманд утаа сорогч шинээр суурилуулж, зуухны заалны гэрэлтүүлгийг шинээр сольж тавьж, зуухны заалны агаарын бохирдлыг бууруулан орчны гэрэлтүүлгийг сайжруулсан.</p>



Зуухны заалны гэрэлтүүлэг



утаа сорогч



Инвертерүүд



3 Уурын зуухны үнс барих төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж найдвартай ажиллагааг хангах, үнсийг цаг тутам авч, яндангаар гарах утааны хийд агуулагдах үнс тоосыг багасгах.

жилдээ

230,000.00

Бүх зууханд нарийн үнс баригчийг суурилуулан зуухны үнс барих төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, найдвартай ажиллагааг хангах, нүүрсийг бүрэн шатааж дуусах бүрт үнсийг авч, утаа сорох дымсос яндангаар гарах утааны хийд агуулагдах үнс тоосыг багасгасан. Нарийн үнс баригчийг тогтмол цэвэрлэн ажиллаж байна. Хаягдал утааны хэмжилтийн сорьц авах төхөөрөмжийг зуухнуудын янданд суурилуулсан.



Утааны хэмжилтийн сорьцын төхөөрөмж



Нарийн үнс баригч


Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

4	Усны дээжийн шинжилгээ хийлгэх, стандарт хангасан цэвэр усаар хангах	жилдээ	426,900,00	Хүн амын ундны усны эх үүсвэр, гүний худгийн болон өргөх станц, усан сангийн ундны усны дээжийн шинжилгээг сар бүр буюу Говьсүмбэр аймгийн Хэмжил зүйн хэлтсийн лабораторит 8 удаа, Усны газрын лабораторит 1 удаа Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторит 1 удаа нийт 10 удаа шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний дүн ундны усны MNS 0900:2018 стандартад нийцсэн. Хүн амыг ундны усны MNS
---	--	--------	------------	--

				0900:2018 стандартыг хангасан цэвэр усаар ханган ажиллаж байна.
5	Усны эх үүсвэрийн хамгаалалтын хашааг засварлах	жилдээ	500,000.00	Усны эх үүсвэрийн 1,2 дугаар өргөх станцын эрүүл ахуйн хориглолтын бүсийн хамгаалалтын 50х50 хашааг засварлан, орчны цэвэрлэгээг хийж, 1 дүгээр өргөх станцын худгийн барилгын дотор талд засвар хийн эрүүл ахуйн шаардлага стандартыг хангасан. “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх” журмын хэрэгжилтийг ханган эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөн ажилласан.
6	Хаягдал усны дүгнэлт гаргуулах, зөвшөөрөл авах, гэрээ байгуулах	жилдээ	17,580.00	Хаягдал усны дүгнэлтийг МУЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар гаргуулан Умард говийн гүвээт халхын дундад талын сав газартай гэрээ байгуулан, хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрлийн эрхийн бичгийг авч, ус бохирдуулсны төлбөрийн 17580 төгрөгийг Говьсүмбэр аймгийн татварын дансанд төвлөрүүлэн “Ус бохирдуулагчийн төлбөрийн тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.
7	Хаягдал усны шинжилгээ хийлгүүлэх, байгальд стандартанд нийцсэн бохир ус нийлүүлж байгаа эсэхэд хяналт тавих	жилдээ	413,800.00	Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторит бохир ус буюу хаягдал усны дээжийг 1 удаа, Усны газрын лабораторит 1 удаа, ГСА-ийн Цаг уур орчны шинжилгээний төвийн лабораторит 2 удаа шинжлүүлсэн. Стандарт нийцсэн бохир усыг байгальд нийлүүлэх зорилгоор бохирын хяналтын 75 худгуудыг лайдаж, шугамыг сэтгэж, цэвэрлэн ариутгал хийсэн. Мөн нийтийн орон сууцны байрнуудын техникийн давхаруудад ариутгал хийсэн. Бохир усны чанар байдалд хяналт тавин шинжилгээнд хамруулан ахуйн бохир усны MNS4943:2015 стандартад нийцсэн усыг байгальд нийлүүлж байна.
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
8	Хөрсөн бүрхэвчийн нянгийн бохирдлыг халдваргүйжүүлэх.	жилдээ	400,000.00	Бохирын төв 1,2 км шугамын дагуу байрласан хяналтын 28 худгийн лагийг зөөж цэвэрлэсэн. Бохир усны төв шугам сүлжээ хэвийн үйл ажиллагаанд орж хуучин хөрсийг бохирдуулж байсан хэсгийг хөрсний


нянгийн бохирдлыг халдваргүйжүүлэх ариутгал хийсэн.
Байгууллагын дулаан түгээлтийн үйл ажиллагаа хэвийн явагдаж
байгаа үед Говьсүмбэр аймаг дахь Цаг уур орчны шинжилгээний
төвийн лабораторт хөрсний шинжилгээг 2 удаа хийлгэж хөрсний
бохирдолд хяналт тавин ажилласан






				
9	<p>Үйлдвэрлэлийн орчны хог хаягдлыг тогтмол цэвэрлэх, хуваарьт талбай, сумын хэмжээнд зохион байгуулж буй цэвэрлэгээний ажилд оролцож байх</p>	жилдээ	860,000.00	<p>Байгууллагын ойр орчмын 100 метрээс доторх талбай, хашааны дотор талын хог хаягдлыг үйлчлэгч тогтмол цэвэрлэгээдэг ба нийт ажилчид 14 хоног тутам цэвэрлэгээг хийдэг. нийт 36 удаа цэвэрлэгээг хийсэн. Нийтийн эзэмшлийн хуваарьт талбай, бүх нийтийн цэвэрлэгээг 6 удаа зохион байгуулахад оролцож, хогийг тогтмол цэвэрлэж, сумын засаг даргын тамгын газарт албан тоотоор 6 тайлан мэдээг хүргүүлэн ажилласан. Нийтийн эзэмшлийн хуваарьт талбай нь цэвэрлэгээг томилогдсон үйлчлэгч тогтмол цэвэрлэдэг. Албан хаагчдын дунд хог хаягдлын тухай сургалт зохион байгуулж, ангийн ялгах хогийн савны таних тэмдгийг танилцуулсан. Байгууллагын “Хог хаягдлын менежмент”-ийн төлөвлөгөөний дагуу 2023 оны “Хог хаягдал”-ын төлөвлөгөөг гарган дараа ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын ойр орчмын 100 метрээс доторх талбай хашааны дотор талын хог хаягдал, цас мөсийг 14 хоног тутам нийт 36 удаа цэвэрлэж орчны тохижилтыг сайжруулж, ногоон байгууламжийн арчилгаа, усалгааг хийж ажилласан 2. Нийтийн эзэмшлийн хуваарьт талбайн цэвэрлэгээ, бүх нийтийн цэвэрлэгээг 6 удаа зохион байгуулсан 6 удаа оролцож, сумын засаг даргын тамгын газарт албан тоотоор 6 тайлан мэдээг хүргүүлэн

ажилласан.






				<p>2. Байгууллагын нийт албан хаагчдад хог хаягдлыг ангилан ялгах зөв дадал , мэдлэг олгох сургалт зохион байгуулж, мэдээлэл өгч, хог хаягдлыг ялган хэвшүүлэн ажиллаж байна.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p>3.Халаалтын зуухнаас гарсан үнсийг тусгай талбайд хуримтлуулан 2, 8 дугаар сард сумын төв хогийн цэгт 285 тн үнсийг тээвэрлэн асгаж, үнсний талбайг цэвэрлэсэн.</p> <p>4. Хог хаягдал гаргасны төлбөр 600000 төгрөгийг нэхэмжлэхийн дагуу сумын орлогын дансанд төвлөрүүлсэн. Мөн албан хаагчдын ахуйн хог хаягдлын 2022,2023 оны төлбөрийг сумын хог хаягдлын дансанд төвлөрүүлсэн.</p>
10	<p>Үнс хаях цэгийг стандартын дагуу шинээр бий болгох / хатуу хучилттай болгох/, үнсийг тогтмол зайлуулж байх.</p>	жилдээ	5,760,000.00	<p>Зуухны шаталтын горимд хяналт тавьж, нүүрс агаарын харьцааг жигд болгосноор зуухнаас гарч буй үнс, хаягдлын хэмжээ багассан. Үнс хаягдлыг галалгаа эхлэж, дулаан түгээж байгаа үед 2, 8 дугаар сард төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн хаяж, үнсний талбайг цэвэрлэж ажилласан. Үнс хаях цэгийг стандартын дагуу хатуу хучилттай болгох ажил санхүүгийн боломжгүйгээс хийгээгүй.</p>



Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

11	Бүх нийтээр мод тарих ажилд идэвхитэй оролцож Байгууллагын хашаа, Алсын худаг, Сумын төв талбайд мод тарих	жилдээ	1,750,000.00	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Шивээговь сумаас ойн бүсэд хавар 05 сарын 12-ны өдөр 50 ширхэг хайлаас, 05 сарын 10-ны өдөр Усны эх үүсвэрийн 1 дүгээр өргөх станцын хашаанд 250 ширхэг хайлаас, Шивээговь сумаас ойн бүсэд намар 10 сарын 24-ны өдөр 50 хайлаас тарьсан бөгөөд 15 албан хаагч 150 ширхэг, байгууллага 200 ширхэг хайлаасыг нийт 350 ширхэг хайлаас тарьсан. Нийт 1,750,000.00 төгрөгөөр зарцуулсан. Байгууллагын ногоон байгууламжийн чацаргана болон бусад төрлийн модыг 7 хоног бүр усалгаа арчилгааг үйлчлэгч-усан санч Д.Амаржаргал, нярав Г.Золзаяа нар хариуцуулан хийж, 10 сард цэнэг усалгаа хийгдсэн. Модны ургалт 80 хувьтай бөгөөд байгууллагын ногоон байгууламжийг 2500 м²-аар</p>
----	--	--------	--------------	--

				<p><i>нэмэгдүүлсэн.</i></p> 
--	--	--	--	---

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

12	Усны эх үүсвэрт нөөцийн насос худалдан авах	8,500,000.00	<p><i>Усны эх үүсвэрийн 1 дүгээр өргөх станцын худгийн насосыг шинээр солих ажлыг хийж гүйцэтгэн Шивээговь сумын хэрэглэгчдийг цэвэр усаар найдвартай хангаж байна. ЭЦВ маркын усны насосыг худалдан авч нөөцөнд бэлтгэсэн.</i></p> 
----	---	--------------	---

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний хэрэгжилт

13	“Илчлэг-Шивээ”ОНӨААТҮГ болон сумын ард иргэдэд Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж мэдээлэл өгөх.	10 сар	780,000.00	“Хэрэглэгчээ сонсоё” нээлттэй хаалганы өдөрлөгийг 9 сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Шивээговь сумын иргэдэд байгууллагын үйл ажиллагаа, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, тайлан, улсын төсвийн хөрөнгө, аймаг, сумын орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдсэн болон хийгдэж буй ажлууд, засвар үйлчилгээ, цэвэр, бохир ус, дулааны төлбөрийн мэдээллийг Bill центр-ээр төлөх зааврыг танилцуулан үнэн зөв мэдээлэлээр хангаж, 4 төрлийн боршур, усны ухаалга хэрэглээ болон суултуурыг зөв зохистой хэрэглэх тухай 10 төрлийн зөвлөмжийг 700 ширхэгийг хэвлэн тарааж иргэдийг мэдээллээр хангаж, байгууллагын үйл ажиллагаа, ус, дулаан хангамжийн талаар санал асуулгад авч, сумын нийт иргэн хамрагдсан. Байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдээс судалгаа авч, судалгааны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан.
----	---	--------	------------	---



				
	<p>Дүн</p>		<p>22,666,280.00</p>	

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН БИЧСЭН: ИНЖЕНЕР Д.АЛТАНЦЭЦЭГ

